

Монгол улсын төрөлт ирээдүйд доогуур түвшинд очих уу?

Тотас Спүүренбург, доктор

*Монгол улсын их сургууль, Эдийн засгийн сургууль,
Хүн амын сургалт судалгааны төвийн зочин багш*

Б. Энхцэцэг, доктор

*Монгол улсын их сургууль, Эдийн засгийн сургууль,
Хүн амын сургалт судалгааны төвийн дэд профессор*

Англи хэлнээс орчуулсан Ө. Эрдэнэчимэг

*Монгол улсын их сургууль, Эдийн засгийн сургууль,
Хүн амын сургалт судалгааны төвийн судлаач*

Монгол улсын хүн амын төрөлт буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2007 онд 2.34 болсон нь Зүүн Азийн бусад оронтой харьцуулахад өндөр үзүүлэлт юм. 2005 онд нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 1.95 болж хамгийн бага түвшинд хүрсэн. Харин түүнээс хойш төрөлтийн түвшин нэмэгдэж байна. Энэхүү илтгэлээр, Монгол улсын хүн амын төрөлтийн хандлагыг харуулах ба Европ болон Зүүн Азийн бусад орны төрөлтийн түвшин доогуур байхад нөлөөлж буй хүчин зүйлсийг Монгол улсын нөхцөл байдалтай уялдуулан авч үзсэн. Илтгэлийн сүүлийн хэсэгт Засгийн газраас авч хэрэгжүүлж буй төрөлтийг дэмжих арга хэмжээ төрөлтийн доогуур түвшинг тэнцвэржүүлж эсвэл өсгөж чадах эсэхийг харуулахыг зорив.

Түлхүүр үгс:

Нэг эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн тоо, төрөлтийн бууралт, хүн ам зүйн шилжилт, төрөлтийг дэмжих бодлого, жендэрийн тэгш байдал

Зүүн Азийн бүс нутгийн улс орнуудын хувьд төрөлт, хүн амын эргэн нөхөгдөх түвшин (нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2.1)-өөс доогуур түвшинд хүрч, буурсаар байна. Япон, БНСУ-д гэхэд л нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 1.3 болж дэлхийн хамгийн бага төрөлттэй орны тоонд орох болсон. Харин БНХАУ-ын хувьд сүүлийн 15-20 жилд төрөлтийн түвшин эргэн нөхөгдөх түвшингээс доогуур түвшинд хүрч, одоогийн байдлаар нэг эмэгтэйд 1.7 хүүхэд ногдож байна. Монгол Улсыг Зүүн Азийн бусад оронтой харьцуулбал (БНАСАУ-ыг оруулахгүйгээр) төрөлтийн түвшин хамгийн өндөр буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2.34 байгаа юм (ҮСХ 2007).

Монгол Улсад төрөлтийн түвшин 2005 онд 1.95-д хүрсэн нь түүхэн дэх хамгийн бага үзүүлэлт болж байсан бөгөөд түүнээс хойш, төрөлтийн түвшин тогтмол нэмэгдэж нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2006 онд 2.07,

2007 онд 2.34 болсон.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын төрөлтийн түвшний өсөлтийн шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, ирээдүйн төрөлтийн хандлагыг Зүүн Азийн бусад оронтой харьцуулахад ямар түвшинд байгаа талаар авч үзнэ.

Монгол улсын хүн амын төрөлтийн чиг хандлага

Монгол Улсыг Зүүн Азийн бусад орнуудтай харьцуулахад төрөлтийн түвшин нэмэгдэж байгаагаас гадна, түүхэн замналын хувьд ч өвөрмөц онцлогтой орон юм. ЗХУ-ын нөлөөнд байсан Зүүн Азийн цорын ганц улс бол Монгол Улс бөгөөд 70 жилийн турш (1924-1991) социализмын замаар замнасан.

Энэ түүхэн он жилүүдэд эрүүл мэнд (хүн амын эрүүл мэндийг сайжруулахаар ЗХУ-

аас орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж оруулж ирсэн), боловсрол, хүн амын амьжиргаанд дорвитой өөрчлөлт хийсэн нь эхийн эндэгдлийг бууруулахад нөлөө үзүүлсэн юм (Ньюперт 1996; Рилей 2005). Монгол Улсын нийгэм, эдийн засаг, хөгжлийн төлөвлөлтөнд хүн амын асуудал гол хүчин зүйл болдог байсан бөгөөд 3-р таван жилийн төлөвлөгөөгөөр (1961-65) хүн амын өсөлтийг урамшуулах албан ёсны тусгай бодлого, арга хэмжээнүүдийг авч эхэлсэн. Тухайлбал, хүүхэд, шинээр гэрлэгсдэд мөнгөн тэтгэмж олгох, алдарт эхийн I, II одон олгох, 4-өөс дээш хүүхэдтэй эхчүүдэд мөнгөн тэтгэмж олгох, 50 наснаас тэтгэвэр тогтоох, гэрлээгүй болон хүүхэдгүй гэр бүлүүдэд тусгай татвар ногдуулах, ажил эрхэлж буй эхчүүдийг хамгаалсан хөдөлмөрийн хууль батлах гэх мэт (Ньюперт 1994; Ньюперт 1996:36). Жирэмслэлтээс хамгаалах², ерөндөг тавих, үр хөндөхийг³ хориглож, зөвхөн эрүүл мэндийн шалтгааны улмаас дээрх аргаас хэрэглэхийг зөвшөөрдөг байсан. Үүний үр дүнд Монгол Улсад 1960-аад оны эхээр нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 7-8 болж, оргил үедээ хүрсэн.

Хүн амын төрөлт 1970-аад оны дунд үеэс буурч эхэлсэн нь (Зураг 1) Засгийн газраас төрөлт ба гэр бүлийг дэмжих бодлогод өөрчлөлт хийсэн үетэй давхцаж байгаа юм. Хүн амын өсөлтийг урамшуулах

хүчтэй бодлоготой байсан хэдий ч 1976 онд ерөндөг суулгахыг хуулиар зөвшөөрсөн. Гэхдээ тодорхой заалтаар тухайлбал, эрүүл мэндийн шалтгаанаар жирэмсэлж болохгүй, хэт орой эсвэл 5 удаа жирэмсэлж байсан эмэгтэйчүүдэд зөвшөөрөх болсон (Ньюперт 1996, х. 36; Гэрэлтуяа болон бусад 2007, х. 802). Харин 1985 онд 5-аас дээш хүүхэдтэй, эсвэл нөхөр нь хөгжлийн бэрхшээлтэй эсвэл нөхөргүй 3-аас дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд үр хөндөлтийг хуулиар зөвшөөрөх болсон. Үр хөндөлт, жирэмслэхээс хамгаалах эм худалдах, хэрэглэх, импортлоход тавьж байсан бүх хоригийг хүчингүй болгосон юм. 1960-1970 онд нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 7-8 байсан бол 1989 он гэхэд 4.6 болж буурчээ. Монгол Улсын хүн амын төрөлтийн бууралтад хүн амын өсөлтийг урамшуулах бодлого ямар үүрэгтэй байсан талаар ямар нэгэн судалгаа, шинжилгээний ажил өнөөг хүртэл хийгдээгүй л байна.⁴


Социалист систем 1990 онд задран унаж, ардчилал, зах зээлийн эдийн засаг руу шилжиж, 1992 оноос жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл чөлөөтэй нэвтэрч, 1993 он гэхэд нэг эмэгтэйд ногдох төрөлт 2.53 болтлоо огцом буурч, 2002 онд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшин 2.1, 2005 онд 1.95 буюу хамгийн доод цэгтээ (Зураг 1) хүрсэн байна.

² Монгол улсад жирэмслэхээс хамгаалах дааврын эм уух аргыг 1969 онд хориглосон (ЗХУ 1974 онд хориглосон) (Ньюперт 1994, х.18)

³ 1943-1985 онд үр хөндөлтийг хатуу хориглодог байсан ба зөвхөн эрүүл мэндийн шалтгаантай тохиолдолд зөвшөөрдөг байсан

⁴ Монгол улсад төрөлтийн түвшин буурч эхэлсэн үзэгдэл нь хүн амын шилжилтийн анхны дүр зураг мэт санагдаж байна. Гэхдээ энд тэр талаар дэлгэрүүлэн ярилцахгүй.

Зураг 1. Монгол Улс дахь төрөлтийн түвшин ба хүн амын бодлого, 1963-2008



Эх сурвалж: Ньюперт 1994; ҮСХ 2004, 2006, 2007, 2008, 2009.

Монгол Улсын 1970-1980 оны төрөлтийн бууралтад нөлөөлсөн гол хүчин зүйл нь үр хөндөлт байсан (Ньюперт 1994). НҮБХАС Монгол Улсад хэрэгжүүлэх эхний 5-жилийн хөтөлбөрөө 1992 онд эхэлж, хоёр, гурав дахь 5-жилийн хөтөлбөрөө 1997, 2001 онд хэрэгжүүлсэн билээ. Эдгээр хөтөлбөрүүдээр гэрбүлтөлөвлөлтийн аянгулс даяар амжилттай зохион байгуулсан ба үүний үр дүнд 1990 оны эхээр нөхөн үржихүйн насны охидын 11 хувь нь жирэмслэхээс хамгаалах эмийг хэрэглэж байсан бол 1994 онд 25 хувь болж өсчээ (Ньюперт 1996, х. 41; Пенди 1997). НҮБХАС-ийн 2 дахь таван жилийн хөтөлбөр 1997 онд эхэлж, бүх эмэгтэйчүүд албан ёсны эрүүл мэндийн төвүүдээс жирэмслэхээс хамгаалах эмийг үнэ төлбөргүй авах боломжтой болсон. Жирэмслэлтээс хамгаалах эм хэрэглэдэг нөхөн үржихүйн насны охид 1998 онд 33.4 хувь байсан бол 2003 онд 45.3 хувь болж өссөн (Үндэсний Статистикийн Хороо, НҮБХАС 1999, 2004) бөгөөд ер нь 1990-ээд оноос эхэлж


эмэгтэйчүүд үр хөндөхөөс илүү жирэмсэлтээс хамгаалах эм уух болсон гэж дүгнэж болно.

1980-2008 оны насны бүлэг дэх төрөлтийн түвшний өөрчлөлтийг Зураг 2А-д харуулав. Сүүлийн 30 жилд төрөлт бүх насанд буурсныг зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгэм рүү шилжин орсонтой холбон тайлбарлаж болно. Харин 2Б хэсэгт 1980 оноос хойш х болон х+п нас хүрсэн хүүхдүүдийн тоог харуулж байгаа ба сүүлийн 30 жилд төрөлтийн түвшин 20-34 насныхны дунд ихэвчлэн явагдсаныг харж болно. Ер нь төрөлтийн түвшин шилжилтийн үеэс өмнө буурч эхэлснийг Зураг 1-ээс харж болно (1980 онд гарсан хүн амын бодлого, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой).


Төрөлтийн хэмжээ 20-39 настай эмэгтэйчүүдийн дунд 2005 оноос эхлэн нэмэгдсэн ба 25-29, 30-34 насныхны дунд илүү ихээр ажиглагдах болсон.

Зураг 2. Монгол улсын насны бүлэг дэх төрөлтийн түвшний өөрчлөлт ба х болон х+n нас хүрсэн хүүхдүүдийн тоо 1980-2008

Хэсэг А. Насны бүлэг дэх төрөлтийн түвшин/мянгаар/



Хэсэг Б. х болон х+n нас хүрсэн хүүхдүүдийн тоо /мянгаар/



Эх сурвалж: ҮСХ-ны тоо мэдээлэл.

Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшин 2005 онд төрөлтийн эргэн нөхөгдөх түвшингээс доогуур буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 1.95-д хүрсэн нь Монгол Улсын хувьд нэлээд анхаарал татсан асуудал болсон юм. Социалист нийгмийн үед жирэмсэн эхчүүдэд дөрвөн сарын турш цалинтай чөлөө олгох, хүсвэл хоёр жил хүртэлх хугацаанд цалингүй чөлөө өгөх, хөхүүл эхчүүдийн чөлөө авсан цагуудад цалингаас хасахгүй байх, хүүхэд нь гурваас доош настай эхийг ажлаас нь халж болохгүй гэх мэт эх, хүүхдийг дэмжсэн хөдөлмөр хамгааллын хууль үйлчилж байсан. Мөн энэ үед төрөлт ба гэр бүлийг дэмжих хөтөлбөрийг баталсан.⁵ 2006 оны 11 сараас хойш шинээр гэрлэгсэд, шинээр төрсөн хүүхэд, 18 нас хүрээгүй хүүхэд бүрт сарын болон улирлын мөнгөн тэтгэмж олгох болсон.⁶ 2006 онд нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2.07, 2007 онд 2.34 болж өссөн байна (Зураг 1).

Төрөлт нэмэгдэж эхэлсэн нь Азид гарсан Алтан гахай жилтэй холбоотой. Зүүн Азийн зарим оронд, жишээлбэл Хятад, БНСУ-д гахай жилд төрсөн хүүхэд, ялангуяа эрэгтэй хүүхэд азтай, өөдөлж дэвшсэн хүн болно гэж үздэг ажээ. Билгийн тооллоор 1 жаран жил нь нэг тойрог үе (5 шинж чанартай, 12 жилийн амьтан) болдог. Тэгэхээр Алтан гахай жил болох дараагийн үе бол 2067 он. 2008 оны эхний улирлын төрөлтийн мэдээллээс харахад төрөлтийн түвшин 2007 онтой харьцуулбал нэмэгдсэн ба төрөлтийн энэхүү өсөлт цаашид хадгалагдах уу эсвэл тогтонги байх уу гэдэг нь өнөөдөр таамаглал төдий байна.

Монгол Улсын хүн амын төрөлтөд нөлөөлж буй хүчин зүйлийг авч үзвэл дийлэнхи нь төрөлтийг бууруулах хүчин зүйлс байна. Төрөлтийг бууруулж буй хүчин зүйлс төрөлтийг дэмжиж буй хүчин зүйлсээс илүү хүчтэй байна уу үгүй юу гэдэг талаар дараагийн хэсэгт авч үзье.

⁵ Ядуурлыг бууруулах зорилгоор (НҮБХС 2007) эдгээр арга хэмжээнүүдийг (18 нас хүрээгүй хүүхэд бүрт сар, улирал тутамд мөнгөн тэтгэмж олгох) анх баталж байсныг дурьдах хэрэгтэй.

⁶ Эдгээр арга хэмжээнүүдийг 2008 оны 6 сарын 29-нд болсон Их Хурлын сонгуулийн сурталчилгаатай холбон хүмүүс ярьдаг ба Засгийн Газар энэ талаар дахин нэмж засвар хийгээгүй байна.

Монгол Улсын сүүлийн жилүүдийн төрөлтийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлс

Монгол Улсын хүн амын төрөлтийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлохын тулд Ази, Европын бага төрөлттэй орнуудын жишээг төрөлтийн цаг хугацаа (tempo) болон тоо хэмжээтэй (quantum) холбон тайлбарлая.

Хожуу төрөлт

Бага төрөлттэй орнуудад ажиглагдаж буй нэг гол нийтлэг хүчин зүйл бол хожуу төрөлт юм (Биллари 2008). Хожуу төрөлт гэдэг нь хувь хүн болон хосууд нас ахиад ирэхээрээ хүүхэдтэй болох үзэгдэл юм. Европын орнуудын жишээн дээр тулгуурлан төрөлтийг хойшлуулдаг 3 хүчин зүйлсийг Биллари (2004, х. 4) тодорхойлжээ.

Үүнд:

- 1) Хүн ам зүйн хоёр дахь шилжилт,
- 2) Эмэгтэйчүүдийн боловсролын түвшний дээшлэлт,
- 3) Залуучуудын дундах ирээдүйн тодорхойгүй байдал.


Эдгээр хүчин зүйлсийг Монголын нөхцөл байдалтай уялдуулан авч үзлээ. Хүний гэрлэх, хүүхэдтэй болох сонголтыг ахимаг насандаа хойшлуулах нь хүн ам зүйн хоёр дахь шилжилтийн гол шинж чанар юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн үзэл бодол (хувь хүний эрх чөлөө, жендэрийн тэгш байдал...) нэлээд их өөрчлөгдөн хувьсаж байна гэсэн үг. Түүнчлэн “Хүн ам зүйн үүднээс үүнийг хувь хүнд ирж буй

эрх чөлөө, олон талт нөхцөл байдлыг хүлээн авч, сонголт хийх цаг үе гэж хэлдэг” (Ван да Каа, 2001, х. 296).


Европт хүмүүсийн анхны төрөлт, гэрлэлт хойшилж буй шалтгааныг хүмүүсийн үзэл бодол өөрчлөгдөж буй хүн ам зүйн хоёр дахь шилжилттэй холбон тайлбарладаг. Харин Азийн улс орны хувьд гэрлэлтийн байдал өөрчлөгдөж, гэр бүл дэх төрөлтийн хэмжээ буурч байгаа нь төрөлт багасахад нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна (Жонс 2007). Монгол Улсын хувьд ч мөн адил гэрлэх нас хойшлогдсоор байгааг тоон мэдээлэл харуулж байна. Тодруулбал, 1979 онд гэрлэлтийн дундаж нас 18.5, 1989 онд 19.7, 2000 онд 23.7 (ҮСХ 2002) байсан бол иргэний бүртгэлийн мэдээллээс харахад 2007 онд гэрлэх дундаж нас 26.3 болжээ. Анхны төрөлт, анхны гэрлэлтийн талаарх тоо мэдээг үндэслэн амьдрах чадварын шинжилгээ (survival analysis) хийлээ. Энэ шинжилгээгээр Монгол Улсын залуучуудын дунд нэг талаас гэрлэлтээ хойшлуулах, нөгөө талаас залуу охид жирэмслэх үйл явц зэрэг явагдаж байна (Зураг 3). Гэхдээ гол өөрчлөлт нь огт гэрлэж байгаагүй эмэгтэйчүүдийн дунд ажиглагдаж байна (Зураг 3-ын А хэсэг). Шилжилтийн өмнөх ба дараахь үеийн гэр бүл дэх төрөлтийн талаар хийсэн судалгаанаас үзвэл, гэрлэсэн хосууд хүүхэд төрүүлэхийг нэлээд хойшлуулах хандлагатай болсон (1990 оноос жирэмслэлтээс хамгаалах эм нээлттэй болсонтой холбоотой байж болно) ба эсвэл хоёр хүүхэдтэй болоод дахин нэмж хүүхэдтэй болохоо зогсоох болсон байна (Спүүренберг 2008).

Зураг 3. Анхны гэрлэлтийн үе (Хэсэг А) ба анхны хүүхэд төрүүлэх үе (Хэсэг В), Монгол Улс

Хэсэг А: Анхны гэрлэлтийн хугацаа



Хэсэг В: Анхны хүүхэд төрүүлэх хугацаа



Эх сурвалж: - Хэсэг А: 1998 оны НҮЭМС (1948-1953 онтой хэсэг) болон 2003 оны НҮЭМС (үлдсэн бүх хэсгүүд)-уудаас тооцоолж гаргав. Хэсэг Б: 1998 оны НҮЭМС-наас тооцоолж гаргав. **Жич (Хэсэг А):** Эхний ба сүүлийн хэсэг 6 жилээр өгөгдсөн. Учир нь 1948 онд төрсөн эмэгтэйчүүдийн тоо цөөн байсан тул дараагийн хэсгийн тоотой нийлүүлсэн байгаа. Хамгийн сүүлийн хэсэгт байгаа 1988 оны төрөлтийн тоо хангалтгүй хэмжээтэй (2003 оны НҮЭМС 10 сараас 12 сарын дотор явагдсан) байгаа тул эхний 5 жилийн төрөлтийн тоон хэсэгт оруулсан болно.

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилж байгаа нь гэр бүл төлөвлөлт, төрөлт хойшлогдож буй нэг том шалтгаан юм. Европд хийгдсэн судалгаануудаас харахад эмэгтэйчүүд сурч боловсрохыг эрхэмлэх болсон нь гэрлэлт болон хүүхэд төрүүлэхтэй нь зөрчилддөг байна (Колер 2002; Биллари болон Филиппов 2004). Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдсэнээр тэдний эрх чөлөө, гэрлэлт, хүүхэдтэй болох гэх мэт асуудлуудын талаархи үзэл бодолд нь өөрчлөлт орж, нөлөөлж байна гэсэн үг юм. Эндээс энэ хоёр хүчин зүйл (үзэл бодлын өөрчлөлт, боловсрол) харилцан уялдаатай байж, бие биедээ нөлөөлдөг нь харагдаж байна. Социализмын боловсролын систем монгол эмэгтэйчүүдийн боловсролын түвшин хурдацтай нэмэгдэхэд нөлөөлж байсан бол ардчилал, зах зээлийн тогтолцоо руу шилжсэнээс хойш эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрчүүдийнхээс хавьгүй илүү болж, боловсрол дахь жендэрийн асуудлыг бий болгосон. Монгол Улсын сургуулийн насны хүүхдийн хүйсийн харьцаа

Азидаа хамгийн өндөр зөрүүтэй байна (АНДЭЗНК 2007, х. 74). Үүнд нөлөөлсөн гол шалтгаан нь эцэг, эхчүүдийн хүүхдүүддээ хийж буй хөрөнгө оруулалт, зах зээлийн эдийн засаг руу шилжихэд гарсан бүтцийн өөрчлөлт юм. Эцэг, эхчүүд охиддоо илүү боловсрол олгохыг эрмэлзэж, харин эрэгтэй хүүхдүүддээ хөдөө мал дээр гаргах болсон. Тодруулбал, 1992 онд малыг хувьчилснаар эрэгтэй хүүхдүүдийн тодорхой хэсэг нь гэр бүлийнхээ хувьчлагдсан малыг маллаж, сургуульд тоотой хэд нь л явах болсон байна. Дээд боловсрол эзэмшиж байгаа оюутнуудын хүйсийн харьцаа 2005 оны байдлаар 162 эмэгтэйд 100 эрэгтэй болжээ (Азийн улсууд дотор хамгийн өндөр үзүүлэлт ба Зүүн Азийн бусад орнуудын түвшингээс харьцангуй өндөр байна) (АНДЭЗНК 2007, х. 70). Монгол эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмших болсон нь тэд өөртэйгээ ижил түвшний боловсролтой хос олоход хүндрэл үүсгэж, гэрлэлт, төрөлт хойшлогдоход хүргэж байна.

Эдийн засгийн тогтворгүй үед амьдарч,

ажиллаж буй залуу үеийнхний дунд байгаа тодорхойгүй байдал Европ, Зүүн Азид гэрлэлт, төрөлтийг хойшлуулж буй бас нэг хүчин зүйл болж байна. Хуучин социалист Төв ба Зүүн Европын орнуудад төрөлтийн түвшин шилжилтийн үед огцом буурсан. Эдгээр улсад хүмүүсийн өдөр тутмын амьдрал (эдийн засгийн эргэлт, нийгмийн өөрчлөлт) огцом өөрчлөгдөж, ирээдүй нь тодорхойгүй болсон. Өөрөөр хэлбэл, хүмүүс гэр бүл, хүүхэдтэй болохоос илүү амиа хэрхэн зогоох вэ гэсэн асуудалтай тулгарсан. Хямралын үед хүмүүс гэр бүл, үр хүүхэдтэй болох нь сайн сайхан амьдрах боломжийг бууруулна гэж үздэг байсан тул гэр бүл, хүүхэдтэй болох асуудлыг хойшлуулж, эсвэл цөөн хүүхэдтэй байх зэргээр зохицуулж байсан (Колер 2002; Филиппов ба Дорбиц 2003, х. 157-164). Социалист систем 1991 онд нуран унасан явдал нь бусад социалист орнуудыг бодвол Монгол Улсад илүү ихээр нөлөөлсөн (Бруун ба Одигаард 1995, х. 23).

Нийгэм, эдийн засгийн шинэ орчин нөхцөлд тохируулан хүмүүс шинэ арга барил хэрэглэх шаардлагатай болсон. 1990 оноос эхлэн хүмүүс нөхөн үржихүйн талаар өөр байр суурьтай болж, хүүхэдтэй болох асуудлыг хойш тавих болсон (Спүүренберг 2008). Хэдийгээр нийгмийн хамгийн хэцүү цаг үе хойно хоцорсон ч хүмүүсийн дунд эдийн засаг, нийгмийн тэгш бус байдал улам газар авсаар байгаа ба хүмүүсийн ирээдүйн талаархи итгэл найдвар тодорхойгүй байсаар байна. Залуу хүмүүс ажил төрөлтэй болохын тулд маш их өрсөлдөөнтэй тулгарч байгаа нь хүүхэдтэй болох асуудлыг хойшлуулахад нөлөөлж байна.

Төрөлтийн ‘Тоо Хэмжээ’ (quantum)

Хожуутөржбуйхүмүүсцөөнхүүхэдтэйболдог нь нотлогдсон. Билларигийн тодорхойлсноор (2008, х. 6), “хосууд хоёр ба гурван хүүхэдтэй байх хандлага”-ыг төрөлтийн тоо хэмжээ / quantum/ гэнэ. Хүмүүс нэг хүүхэдтэй болсны дараа нэмж хүүхэд төрүүлэхгүй гэсэн бодолд юу нөлөөлдөг болохыг ойлгох хэрэгтэй. Үүнд гурван шалтгаан байна (Биллари 2008 х. 6): 1) фамилизм ба нийгмийн халамж хамгаалал, 2) жендэрийн дэг, 3) хүүхдийн эдийн засгийн зардлууд.

Судалгаанаас үзэхэд гэр бүлийн харилцаа сайтай Өмнөд Европын орнуудад (Итали, Испани, Грек) төрөлтийн түвшин хамгийн

доогуур байна. Үүний цаад учир нь иргэдийн нийгмийн халамж, хамгааллын байдал гэр бүлийн харилцаанд саад болох ёсгүй гэсэн ерөнхий зарчим юм. Зүүн болон Төв Европын орнуудад социалист дэглэм нуран унаж, гэр бүлд чиглэсэн бодлого багассан нь гэр бүл төвтэй Өмнөд Европтой адил болоход хүргэсэн. Эдгээр бүсэд насанд хүрсэн залуу хүмүүс болон тэдний хүүхдүүдэд зориулсан дорвитой нийгмийн халамжийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэггүй, жирэмсэн байх хугацаандаа ажил хийх, сурч боловсрох боломж хомс байдаг. Хуучин социалист орнуудын нэг болох Монгол Улсын хувьд Зүүн ба Төв Европын нөхцөл байдалтай нэлээд төстэй. Социалист систем унаж, Монгол Улсад явуулсан өөрчлөлтүүдийн үр дагавраар нийгмийн хамгааллын арга хэмжээ багассан.

Өмнөд Европын гэр бүлд жендэрийн тэгш байдал нэлээд доогуур түвшинд байдаг. Төрөлтийн түвшин доогуур байгаа шалтгааныг ойлгохын тулд жендэрийн тэгш байдлын хоёр төрлийг (гэр бүл төвтэй тогтолцоон дахь жендэрийн тэгш байдал, хувь хүн төвтэй тогтолцоон дахь жендэрийн тэгш байдал) ялгаж салгаж ойлгох ёстой гэсэн санааг МкДоналд (2000) дэвшүүлжээ. Тэрээр жендэрийн тэгш байдал харьцангуй өндөр байдаг хувь хүн төвтэй нийгэм (боловсрол, хөдөлмөрийн зах зээл) болон жендэрийн тэгш байдал бага байдаг гэр бүл төвтэй нийгэм хоёул зэрэгцэн оршиж байвал төрөлтийн түвшин бага байхад нөлөөлдөг гэжээ. Учир нь нэг талаас, ийм нийгэмд амьдарч буй эмэгтэйчүүд үргэлж боловсролын түвшингээ дээшлүүлж, өндөр цалинтай ажил хөдөлмөр эрхэлж байдаг ч нөгөө талаас, уламжлалт үүргүүдээ (хүүхэд төрүүлэх, өсгөх, гэр орны ажил, настнаа асрах гэх мэт) биелүүлэх гэсэн асуудалтай тулгарч байдаг. Гэр бүл дэр жендэрийн тэгш бус байдал Зүүн Азид илүү өндөр байна (МкДоналд 2008, х. 21; Японы талаар Сузуки 2006, х.12). Монгол Улсын жендэрийн тэгш байдлын үзүүлэлт Өмнөд Европын улсуудтай бараг ойролцоо, Зүүн Азийн зарим улсуудынхтай ижил түвшинд байгаа бол хувь хүн төвтэй тогтолцоотой улсуудынхаас дээгүүр, харин гэр бүл төвтэй улсуудынхаас доогуур байна. Монгол Улсад шилжилтийн үеийн дараагаас эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт, дээд боловсрол эзэмших байдал ихэсч, хөдөлмөрийн зах зээлд өндөр албан тушаалд өрсөлдөх байдал нэмэгдсэн ч айлын эзэгтэй байх үүрэг хэвээр

байна. Харин монгол эрчүүдийн гэр бүлээ тэжээх үүрэг хэвээр байна.

Эцэст нь хэлэхэд, төрөлтийн тоо хэмжээнд нөлөөлж буй бодлого нь төрөлтийн түвшин бага улсуудын нийгмийн халамж хамгаалал, жендэрийн байдлаас тийм ч их хамааралтай бус байна (Биллари 2008, х. 8). Төрөлт бага оронд (дахин) хүүхэдтэй болвол ажлаа үргэлжлүүлэн хийхэд амаргүй; эмэгтэйчүүд ажлаа хийхийн хажуугаар хүүхэдтэй болохыг дэмжсэн бодлого дутагдалтай байдаг нь хосуудыгдахин хүүхэдтэй болох эсэх сонголтод нөлөөлдөг. Монголын хувьд хөдөлмөр эрхэлж буй эсвэл сурч боловсорч байгаа хүүхэдтэй эхчүүдийн эцэг, эх нь тэдний хүүхдүүдийг харж ажил, хичээлээ үргэлжлүүлэн хийх бололцоог олгодог. Энэхүү гэр бүлийн уламжлал, үнэт зүйл болсон дэмжлэг залуучуудыг хүүхэдтэй болох боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр болдог. Ингэснээр хүүхэдтэй болох, хүүхдээ өсгөх үүрэг нь ажил хөдөлмөр эрхлэхэд зөрчил болдоггүй. 1990-ээд оны үед хүмүүсийн дунд нэг, хоёр хүүхэдтэй байх хандлага ихэссэнийг үүнтэй холбон тайлбарлаж болох юм (Спүүренберг 2008). Түүнчлэн мөнгөн тусламж үзүүлэх нь их байх тусам төрөлтийн хэмжээг ихэсдэг тул “мөнгө чухал” (Биллари 2008, х. 8). Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогууд ихэвчлэн мөнгөн тэтгэмж (сар, улиралд олгож буй хүүхдийн мөнгө, шинээр төрсөн болон гэрлэсэн хосуудад олгож буй мөнгөн тэтгэмж) олгох дээр тулгуурлаж байгаа нь төрөлтийн түвшин нэмэгдэхэд эергээр нөлөөлж байна.

Төрөлтийн цаг хугацааны өөрчлөлт болон төрөлтийн тоо хэмжээнд нөлөөлж буй дээрхи хүчин зүйлсүүдийг дүгнэхэд, Монгол Улсын төрөлтийг хойшлуулах (гэрлэлт, хүүхэдтэй болохыг хойшлуулах, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх, тодорхойгүй байдал бий болох), хосууд 2 ба 3 хүүхэдтэй байх хандлага нь (төрөлтийн тоо хэмжээн дэх нөлөөлөл), (гэр бүл төвтэй орнуудын нийгэм хамгааллын тогтолцоо, жендэрийн тэгш байдал доогуур байх) ерөнхийдөө Европ ба Зүүн Азийн орнуудтай төстэй байна. Гэхдээ гэр бүлийн уламжлалт үнэт зүйл болсон дэмжлэг, төрөөс явуулж буй мөнгөн тэтгэмжийн арга хэмжээнүүд хамтдаа төрөлтийн түвшинг бууруулж буй нийгмийн хүчин зүйлсүүдийг тэнцвэржүүлэх боломж олгох юм. Мөнгөн тэтгэмж, гэр бүлийн дэмжлэг, гэр бүлд ээлтэй ажлын байрны нөхцөл байгаа үед төрөлтийн түвшин нэмэгддэгийг олон судалгаа гэрчилж

байна (МкДоналд 2006а). Илтгэлийнхээ сүүлийн хэсэгт бид эдгээр хүчин зүйлсийг МкДоналд -ын дэвшүүлсэн тэгш байдал, үр ашиг, үр дүн (МкДоналд 2006а) гэсэн ойлголтын хүрээнд Монголын жишээн дээр авч үзнэ.

Хүүхэдтэй болохыг дэмжих хүчин зүйлсүүдийн талаар авч үзэх нь

Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 5 сарын 5-нд 18-аас доош насны бүх хүүхдэд сар бүр мөнгөн тэтгэмж олгох, шинээр төрсөн (2006 оны 7 сар) болон шинээр гэрлэгсдэд мөнгөн тэтгэмж олгох хууль баталсан. 2006 оны 6 сарын 2-нд хүүхдэд өгөх мөнгийг сарын 3000 төгрөг, шинээр гэрлэгсдэд 500,000 төгрөг, шинээр төрсөн хүүхдэд 100,000 төгрөг тус тус олгох болсон. 2007 оны 1 сарын 1-нээс эхлэн 18-аас доош насны бүх хүүхдэд улирал бүр 25,000 төгрөг нэмэлтээр олгох болсон. Ингэснээр нэг хүүхдэд жилд олгож буй мөнгөн тэтгэмжийн хэмжээ 136,000 төгрөг болсон (2007 оны байдлаар нэг хүнд сард 56,000 төгрөг ногдож, нэг хүнд ногдох ДНБ 1,742,800 төгрөг байв (ҮСХ 2008)) (Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл НҮБХС 2007, хх. 11-12 харна уу). Ядуурлыг бууруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй эдгээр арга хэмжээнүүд төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд давхар нөлөөлж байна. Учир нь мөнгөн тэтгэмжүүд гэр бүлд чухал ач холбогдолтой буюу энэ нь хүүхэд төрсний дараахь эхний хэдэн сард мөнгөний хэрэгцээ шаардлага өндөр байдагтай холбоотой. Түүнчлэн, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой жирэмсэн эхчүүдэд жирэмсэн байх хугацаанд нь 5 сарын турш, төрсний дараахь 7 сарын турш 20,000 төгрөг (НҮБХС 2007, х. 22); төрсөн эхчүүд 4 сарын турш цалинтай амрах (2 жил хүртэл цалингүй амрахаар сунгаж болно); бүх жирэмсэн эмэгтэйчүүд жирэмслэлтийн 5 сараас эхлэн сар бүр 20,000 төгрөгийн тэтгэмж авч байна. Эдгээр мөнгөн тэтгэмжийг олгохоос гадна Монгол Улсын Засгийн газар боловсролын тогтолцоог өөрчлөн шинэчлэхээр болсон. 2008-2009 оны хичээлийн жилээс 7 настайдаа 1-р ангид элсэн ордог байсныг 6 наснаас болгон өөрчилж, 12 жил суралцах болгосон ба 2009 оны 1 сараас эхлэн 2-5 насны хүүхдүүдийг (6 настайдаа 1-р ангид орохоос өмнө) цэцэрлэгт үнэ төлбөргүй хамруулах болсон. Хэдийгээр боловсролын тогтолцоонд хийж буй эдгээр өөрчлөлт шинэчлэлтүүд төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхийг шууд зориогүй ч Монгол Улсын

Засгийн газар улс орныхоо хойч ирээдүй болсон хүүхдүүдийн төлөө анхаарч, санаа тавьж байгаагийн илрэл юм. Энэ нь хүүхэд төрүүлэх насны хосуудад эерэг хандлага бий болоход нөлөө үзүүлж болох талтай. Эерэг хандлага, бодлого хоёулаа чухал ач холбогдолтой (МкДоналд 2008, х. 23, Найер 2006, х. 6-г иш татав).

Төрөлтийг дэмжсэн эдгээр хүчин зүйлс Монгол Улсын хүн амын төрөлтийн хэмжээг тогтворжуулахад хангалттай юу? Төрөлтийн түвшин бага байгаа явдлыг тэнцвэржүүлж чадах уу? МкДоналд (2006б) төрөлтийг дэмжих хүчин зүйлс/бодлогыг 11 шалгуур үзүүлэлтээр гаргаж ирсэн ба тэдгээр нь аливаа улсын хүн амын бодлого, төрөлтийг дэмжих арга хэмжээнүүдийг шалгах/харьцуулахад зориулсан өргөн цар хүрээтэй хэмжээс юм.

Эдгээр 11 шалгуур үзүүлэлтэд:

1. Хүүхдийн үнэ цэнэ;
2. Эцэг, эхийн ажлын нөхцөл байдалд өөрчлөлт орохгүй байх боломж (төвийг сахьсан байдал),
3. Жендэрийн төвийг сахьсан байдал;
4. Ажлын байрыг хуульчилсаны ашиг тус;
5. Хүүхэд хөгжлийн асуудал улс орны бодлогын нэг хэсэг байх;
6. Амьдралын мөчлөг;
7. Энгийн, ил тод байдал;
8. Санхүүгийн тогтвортой байдал;

9. Үр ашигтай байх зарчим;
10. Улс төрийн хувьд хүлээн зөвшөөрч буй байдал;
11. Тогтвортой байх зарчим (МкДоналд 2006б: 219-222) –ууд багтана.

Хүснэгт 1-т МкДоналд -ын дэвшүүлсэн 11 шалгуур үзүүлэлт Монгол Улсын хувьд хэр тохирч байгааг харуулав. Төрөлтийг дэмжсэн арга хэмжээнүүд Монгол Улсад хүүхдийн нийгмийн үнэ цэнэ байгааг тодорхой харуулж байна (Шалгуур 1). Мөнгөн тэтгэмж нь хэвтээ /horizontal/ зарчмаар явж байна. Өөрөөр хэлбэл, “Хүүхэд өсгөж буй хүмүүст хүүхэд өсгөөгүй байгаа хүмүүсээс илүү их нэмэлт зардал гардаг, тэдний орлогын түвшин харилцан адилгүй байдаг тул нэмэлт зардалд өгөх нөхөн төлбөрийг хэсэг хэсгээр ч болов өгөх нь зүйтэй гэсэн зарчим” (МкДоналд 2006б, х. 219). Эцэг, эхчүүдийн нийгэмдээ оруулж буй хувь нэмрийг үнэлэн нийгмээс тодорхой хэмжээний нөхөн төлбөр олгогдоно гэсэн үг .

18-аас доош насны хүүхэд, шинээр төрсөн хүүхэд, шинээр гэрлэгсдэд зориулсан мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрүүд олгож байгаа нь эцэг, эхчүүдийн ажлын нөхцөл байдалд ямар нэг өөрчлөлт оруулахгүй байх (төвийг сахьсан) буюу эцэг, эхийн аль нэг эсвэл хоёулаа ажиллаж байвал алдагдал гарахгүй байх боломжийг бүрдүүлж байна (Шалгуур 2).

Хүснэгт 1. Насны бүлэг дэх төрөлтийн түвшин, боловсролоор, 2003 оны НҮЭМС, Монгол Улс, 2003

Насны бүлэг	Боловсролын түвшин				Нийт
	Бага ба түүнээс доош	Бүрэн бус дунд	Дунд	Дундаас дээш	
15-19	0.0673	0.0584	0.0503	0.0514	0.053
20-24	0.2198	0.1907	0.1643	0.1678	0.173
25-29	0.1779	0.1543	0.1330	0.1358	0.140
30-34	0.1042	0.0904	0.0779	0.0795	0.082
35-39	0.0546	0.0474	0.0408	0.0417	0.043
40-44	0.0089	0.0077	0.0066	0.0068	0.007
45-49	0.0013	0.0011	0.0009	0.0010	0.001
ТНК	3.17	2.75	2.37	2.42	2.50

Эх сурвалж: ҮСХ ба НҮБХАС 2004: 29

Жендэрийн төвийг сахьсан тогтолцоо нь эцэг, эхийн аль нэг хүүхдээ асрахаар ажлаасаа чөлөө авах тэгш боломжийг харуулдаг. Монгол Улсад эхчүүд ихэвчлэн хүүхдээ асардаг нь жендэрийн тэгш байдал доогуур байхад нөлөөлж байна (Шалгуур 3).

Монгол Улсад гэр бүлд ээлтэй ажлын байрны (хүүхдээ, гэр бүлээ асрахад зориулсан чөлөө, ажлын уян хатан цагийн хуваарь, хагас цагийн ажил) хөнгөлөлтүүдийг (жирэмсний амралт, ажлын цагаар хүүхдээ хөхүүлэхэд цалингаас хасахгүй байх) хуульчилж өгсөн. Гэхдээ, гэр бүлд ээлтэй ажлын байрны үзүүлэлт нэлээд хэдэн зүйл дээр доогуур байгаа тул шалгуур 4-ийг үнэлэхэд хүндрэлтэй байна.

Төрөлтийг дэмжих хүчин зүйл/бодлого дан ганц төрөлтийг дэмжээд зогсохгүй, хүүхдийг хүмүүжүүлэх, тэдний боловсролыг дэмжихэд чиглэгдсэн байх ёстой. Үүний дагуу 2009 оны 1 сард 2-5 настай хүүхдүүдийг цэцэрлэгт үнэ төлбөргүй хамруулах шийдвэр гарсан нь эхчүүдэд ажил хийх боломжийг олгож, хүүхэд хөгжих зохистой нөхцлийг бүрдүүлэх зорилготой төрөлтийг дэмжсэн эерэг хүчин зүйл болсон.

Амьдралын мөчлөгийн хандлагаас харахад (шалгуур 6) залуу хосууд хүүхэд төрүүлэхэд тэдний орлого багасч (учир нь эцэг, эхийн аль нэг, ихэвчлэн эмэгтэйчүүд ажиллахаа болих) харин хүүхэд өсөөд ирэх үед буцаад нэмэгддэг. Ажлаа хийхээ болихоос өмнө эхчүүд гэр бүлийнх нь санхүү хангалттай байж чадах эсэх, хүүхдээ хэсэг хугацаанд асарсны дараа буцаад ажилтай болж чадах эсэхийг баталгаатай болгохыг хүсдэг. Тиймээс хүүхэд төрсний дараахь хэдэн жилд Засгийн газар илүү дэмжиж анхаарал тавьж ажиллах ёстой. Төрөлтийг дэмжих хүчин зүйлс гэр бүлийн нөхцөл байдалд тохирсон уян хатан, өөрчилж болохоор байх хэрэгтэй. Шинээр төрсөн хүүхдэд олгож буй мөнгөн тэтгэмж эцэг, эхчүүдэд тустай мэт боловч урт хугацаанд тийм ч их нэмэртэй байж чадахгүй байна.

Монгол Улсад хэрэгжиж буй 18-аас доош насны хүүхэд, шинээр төрсөн хүүхэд, шинээр гэрлэгсдэд зориулсан мөнгөн тэтгэмж энгийн, ил тод хэлбэртэй байна (шалгуур 7).

Социалист нийгмийн түгээмэл нэг зарчим бол шинэ төрсөн нялхас, хүүхэд, шинээр гэрлэгсэд аль улсын иргэн, нийгэм, эдийн засгийн ямар давхаргаас үл хамааран мөнгөн

тэтгэмж авах эрхтэй. Гэхдээ мөнгөн тусламж олгох энэ үйл ажиллагаанд социализмын нэг шинж болсон хүнд суртал тээг болсоор байна. Мөнгө авахын тулд хүмүүс дараахь материалуудыг бэлдсэн байх шаардлагатай байдаг. Үүнд:

1. хүүхдийн мөнгө авахад “хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, эцэг, эх эсвэл асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хувь, баг, хорооны засаг дарга болон сургуулиас тухайн хүүхдийн оршин суугаа, сургуульд сурдаг нь үнэн болно гэсэн тодорхойлолт бичиг;”

2. шинээр төрсөн хүүхдийн мөнгө авахын тулд, “хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хувь, тухайн хүүхэд эрүүл энх өсөн бойжиж байна гэсэн эмчийн тодорхойлолт бичиг, баг, хорооны засаг даргын тодорхойлолт бичиг;”

3. шинээр гэрлэгсдийн хувьд, “гэрлэлтийн баталгаа болон иргэний үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан хувь, баг, хорооны засаг даргын тодорхойлолт бичиг” (НҮБХС 2007, х.11)

Мөнгөн тэтгэмж нь улсын төсвөөс шууд санхүүждэг нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөрийн нэг хэсэг юм. Уул уурхайн компаниудад ногдуулах татвараас орох ашгаас (металын үнэ өндөр байж л байвал) улирал тутам хүүхдүүдэд 25,000 төгрөг олгох ажил 2006 оны дундаас эхэлсэн. Үүнийг Монгол Улсын Хөгжлийн сангаар дамжуулан хэрэгжүүлдэг ба дунджаар нэг хүүхэд жилдээ 136,000 төгрөгийн тэтгэмж авч байна. Үүнийг хувиар бодвол, Засгийн газрын зардлын 9.5%, харин ДНБ-ний 3.9 хувьтай тэнцэж байна (НҮБХС 2007). Эдгээр 3 төрлийн мөнгөн тэтгэмж (18-аас доош насны хүүхдүүд, шинэ төрсөн хүүхдүүд, шинээр гэрлэгсэд) нийлээд 47.8 сая төгрөг болно гэж 2007 онд төсвөлсөн (НҮБХС 2007). Дэлхийн зах зээл дэх металын үнийн өөрчлөлтөөс шалтгаалан улсаас, Монгол улсын Хөгжлийн Сангаас төсөвлөсөн мөнгөн тэтгэмжүүдэд өөрчлөлт орж болзошгүй юм. Азаар мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн үеэс өдийг хүртэл металын үнэ өсч байгаа ч, энэ байдал гадны нөлөөллөөс болж өөрчлөгдөн, тогтворгүйжиж болох эрсдэлтэй. Монгол Улсын хувьд нөхцөл байдал боломжийн байвал мөнгөн тэтгэмжийг олгосоор байх (шалгуур 8) боломжтой.

Төрөлтийг дэмжих хүчин зүйлс үр дүнтэй байх ёстой. Монгол Улсын хувьд мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг ядуурлыг бууруулах

зорилгоор анх баталж байсан. Өөрөөр хэлбэл, ядуу хүмүүсийн тоог j-ээр бууруулж, ядуурлын хэмжээг 50 хувиар бууруулах зорилттой (НҮБХС 2007, х. 16 ба х. 34). Хөтөлбөрийн үр дүн шууд харагдахгүй ч, аажимдаа үр ашиг нь (шалгуур 9) тооцогдоно гэсэн үг.

18-аас доош насны хүүхэд, шинэ төрсөн хүүхэд, шинээр гэрлэгсдэд зориулсан мөнгөн тэтгэмж олгох хуулийг УИХ баталсан нь улс төрийн нэгдмэл байдал байгаагийн илрэл юм. Хэдийгээр зарим хүмүүс дургүйцэж байсан ч ард түмэн энэ хуулийг сайнаар хүлээн авсан (шалгуур 10, улс төрийн хүлээн зөвшөөрөлт) (НҮБХС 2007). Хүүхдийн мөнгө олгохыг зөвшөөрсөн атлаа сурагчдад үнэгүй сурах бичиг олгохыг болиулсан явдалд зарим хүмүүс шүүмжлэлтэй хандаж байна (НҮБХС 2007, х. 25).

Эцэст нь хэлэхэд, төрөлтийг дэмжих аливаа бодлого удаан тогтвортой үргэлжлэх чадвартай байх ёстой (шалгуур 11). Хүүхдийн мөнгө өгөх тухай анхны хэлэлцүүлгүүдэд 2004 оны УИХ-ын сонгууль их нөлөө үзүүлж байсан. Өмнөх Засгийн газрын үед баталсан арга хэмжээнүүдээ 2008 оны 7 сарын 29-нд болсон УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд дахин ашигласан. Хэдийгээр авах арга хэмжээнүүд өөрчлөгдөн шинэчлэгдээгүй ч улс төрийн намууд бүгдээрээ л энэ хуулийг сайшаан хүлээн зөвшөөрсөн. Ашиг шимийг хүртэгч ард түмэн мөнгөн тэтгэмжийг хэрэгцээтэй зөв гэж үзэж буй учир мөнгөн тэтгэмжийн хэмжээг багасгах буюу болиулахад хүндрэлтэй.

Дүгнэн хэлэхэд, Монгол Улсын Засгийн газраас саяхан баталсан төрөлтийг дэмжих бодлогод тэгш байдал, үр ашиг, үр дүнгийн үүднээс анализ хийхэд тэдгээр нь ерөнхийдөө төрөлтийг дэмжсэн шинжтэй байна. Мөнгөний хэрэгцээнээс шалтгаалан мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрүүд төрөлтийг дэмжих хамгийн үр дүнтэй арга болоод байна. Эдгээр хөтөлбөрүүд хүүхдийн нийгмийн үнэ цэнэ, тэгш байдлын зарчмуудыг дээдлэх байдал, эцэг, эхийн ажлын нөхцөл байдлын боломж зэргийг хамруулсан байна. Төрөлтийг дэмжих хамгийн энгийн ба ил тод арга зам бол мөнгөн тэтгэмж олголт юм. Учир нь хүүхэд бүрт ногдох зардлыг шийдэхэд мөнгөн тэтгэмж хувь нэмэртэй байгаа ба төрөлтийг тогтворжуулж байна.

Дүгнэлт

Монгол Улсын төрөлтийн талаарх сүүлийн үеийн судалгаа шинжилгээнээс харахад, төрөлтийн түвшин түүхэндээ хамгийн доогуур үзүүлэлттэй буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 1.95 байсан 2005 оноос хойш төрөлтийн түвшний өсөлт ажиглагдаж байна. Төрөлтийн түвшин 2007 онд 2.34 болж, төрөлтийн эргэн нөхөгдөх түвшингээс дээгүүр түвшинд хүрсэн. Энэ нь Япон, Солонгос дахь төрөлтийн түвшин буюу нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тооноос нэг ба түүнээс дээш хүүхдээр илүү байна. Төрөлтийн түвшний өсөлт зарим насны бүлэгт ихээр ажиглагдаж байгаа ба оройтож хүүхэд төрөх асуудалтай ч холбоотой. Монгол Улсын Засгийн газар гэр бүл, төрөлтийг дэмжин, 18-аас доош насны хүүхэд, шинэ төрсөн хүүхэд, шинээр гэрлэсэн хосуудад мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн нь Монгол Улсын төрөлтийн түвшин нэмэгдэх гол шалтгаан болсон. Төрөлтийг дэмжих эдгээр арга хэмжээнүүдийг баталж хэрэгжүүлсэн хугацаа Билгийн тооллын Алтан Гахай жилтэй давхцсан нь төрөлтийн цаг хугацааны өөрчлөлтийг бий болгосон. Гэхдээ, төрөлтийн түвшин Билгийн тооллын Алтан Гахай жил болохоос өмнө буюу 2006 оноос өсч эхэлсэн. Түүнчлэн статистик тоо мэдээнээс харахад 2008 оны эхний улирлын төрөлт 2007 оныхоос өссөн дүнтэй байна. Эндээс дүгнэхэд, төрөлт нэмэгдэж буй нь зөвхөн цаг хугацааны өөрчлөлтөөс болдоггүйг харуулж байна.

Төрөлтийн доогуур түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг Европ ба Зүүн Азийн орнуудын жишээн дээр авч үзэхэд төрөлтийг хойшлуулж буй хүчин зүйлс нь төрөлтийн тоон хэмжээнд /quantum/ нөлөөлж буй хүчин зүйлсээс өөр байна. Бусад орны төрөлтийн түвшин доогуур байхад нөлөөлж буй хүчин зүйлс (гэрлэх, хүүхэдтэй болох асуудлыг хойш тавих үзэл бодлын өөрчлөлт; эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмших; залуу хүмүүсийн дунд бий болж буй тодорхойгүй байдал) манай оронд ч мөн адил байна. Түүнчлэн төрөлтийн тоо хэмжээнд (quantum) нөлөөлдөг (фамилизм болон нийгэм хамгаалал, гэр бүл төвтэй жендэрийн тэгш байдал доогуур үзүүлэлттэй байгаа нийгэм, хувь хүн төвтэй жендэрийн тэгш байдал өндөр үзүүлэлттэй байгаа нийгэм хоёул хосолсон) хүчин зүйлс ч Монголд тохиолдож байна. Монгол Улсын Засгийн газраас 2006 оноос төрөлт, гэр бүлийг дэмжин мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн

нь төрөлтийн түвшинг өсгөхөд нөлөө үзүүлнэ гэсэн итгэлийг төрүүлж байна.

МкДоналд (2006б)-ийн боловсруулсан тэгш байдал, үр ашиг, үр дүнгийн ойлголтын хүрээнд 11 шалгуур үзүүлэлтээр Монгол Улсын 18-аас доош насны хүүхэд, шинэ төрсөн болон шинээр гэрлэгсдэд олгох мөнгөн тэтгэмжийг авч үзэхэд Монгол Улсад

хэрэгжиж буй дээрх хөтөлбөр 11 шалгуур үзүүлэлтийн ихэнхийг хангаж байгаа ба төрөлтийн бууралтыг тэнцвэржүүлэхэд нөлөө үзүүлж байна. Төрөлтийг дэмжсэн бодлого, арга хэмжээнүүдийг дүгнэхэд Монгол улсын төрөлтийн түвшин ойрын ирээдүйд Зүүн Азийн бусад улс оронд ажиглагдаж байгаа шиг доогуур түвшинд хүрэхгүй байж болохоор байна.

Ашигласан материал

Billari, F.C. 2008. Lowest-low fertility in Europe: Exploring the causes and finding some surprises. *The Japanese Journal of Population* 6(1): 2-18.

Billari, F.C. and D. Philipov. 2004. Education and the transition to motherhood: A comparative analysis of Western Europe. *European Demographic Research Papers Series*. Vienna: Vienna Institute of Demography.

Bruun, O. and O. Odegaard. 1995. A society and economy in transition. Pp. 23-41 in Bruun, O. and O. Odegaard (eds.), *Mongolia in Transition. Old Patterns, New Challenges*. Richmond: Curzon Press.

ESCAP. 2007. *Statistical Yearbook for Asia and the Pacific 2007*. New York: United Nations, available Online at: <http://www.unescap.org/stat/data/syb2007/>

Gereltuya, A. 2008. Dramatic fertility decline in Mongolia and its determinants: the demise of the pronatalist State. *Asia-Pacific Population Journal* 23(2): 81-99.

Gereltuya, A., J. Falkingham and J. Brown. 2007. Determinants of current contraceptive use and method choice in Mongolia. *Journal of Biosocial Science* 39(6): 801-817.

Jones, G.W. 2007. Delayed marriage and very low fertility in Pacific Asia. *Population and Development Review* 33(3): 453-478.

Kohler, H.-P., F.C. Billari and J.O. Ortega. 2002. The emergence of lowest-low fertility in Europe during the 1990s. *Population and Development Review* 28(4): 641-680.

Lutz, W., V. Skirbekk and M.R. Testa. 2006. The low fertility trap hypothesis: Forces that may lead to further postponement and fewer births in Europe. *Vienna Yearbook of Population Research 2006*, Special issue on "Postponement of Childbearing in Europe": 167-192.

McDonald, P. 2000. Gender equity in theories of fertility transition. *Population and Development Review* 26(3): 427-439.

McDonald, P. 2006a. Low fertility and the State: The efficacy of policy. *Population and Development Review* 32(3): 485-510.

McDonald, P. 2006b. An assessment of policies that support having children from the perspectives of equity, efficiency and efficacy. *Vienna Yearbook of Population Research 2006*, Special issue on "Postponement of Childbearing in Europe": 213-234.

McDonald, P. 2008. Very low fertility: Consequences, causes and policy approaches. *The Japanese Journal of Population* 6(1): 19-23.

Neupert, R.F. 1994. Fertility decline in Mongolia: Trends, policies and explanations. *International Family Planning Perspectives* 20(1): 18-22.

Neupert, R.F. 1996. *Population Policies, Socioeconomic Development and Population Dynamics in Mongolia*. Canberra: Australian National University, Research School of Social Sciences.

NSO (National Statistical Office of Mongolia). 2002. *Nuptiality Patterns in Mongolia: Analysis based on the 2000 Census*. Ulaanbaatar: National Statistical Office Press.

NSO (National Statistical Office of Mongolia). 2006. *2005 Statistical Yearbook*. Ulaanbaatar: National Statistical Office Press.

NSO (National Statistical Office of Mongolia). 2007. 2006 Statistical Yearbook. Ulaanbaatar: National Statistical Office Press.

NSO (National Statistical Office of Mongolia). 2008. 2007 Statistical Yearbook. Ulaanbaatar: National Statistical Office Press.

NSO (National Statistical Office of Mongolia) and UNFPA. 2004. Mongolia. Reproductive Health Survey 2003. National Report. Ulaanbaatar: National Statistical Office.

Pandey, R.N. 1997. Knowledge, attitude and practice of family planning in Mongolia. *Demography India* 26(1): 79-92.

Philipov, D. and J. Dorbritz 2003. Demographic Consequences of Economic Transition in Countries of Central and Eastern Europe. Strasbourg: Council of Europe, Population Studies n°39.

Randall, S. 1993. Issues in the demography of Mongolian nomadic pastoralism. *Nomadic Peoples* 33: 209-239.

Riley, J.C. 2005. The timing and pace of health transitions around the world. *Population and Development Review* 31(4): 741-764 and the bibliography published separately on the Web at: «<http://www.lifetable.de/RileyBib.htm>».

Spoorenberg, T. (forthcoming). The impact of the economic and political transition on fertility and family formation in Mongolia: A synthetic parity progression ratios analysis. *Asian Population Studies*.

Suzuki, T. 2006. Lowest-low fertility and governmental actions in Japan. Paper presented at the International Conference on 'Declining Fertility in East and Southeast Asian Countries', organized by PIE and COE/RES, Hitotsubashi University, Hitotsubashi Collaboration Center, Tokyo, Japan, 14-15 December 2006.

UNICEF. 2007. Child Benefits and Poverty Reduction: Evidence from Mongolia's Child Money Programme. New York: UNICEF, Division of Policy and Planning, Working Papers, May 2007.

Van de Kaa, D.J. 2001. Postmodern fertility preferences: From changing values orientation to new behaviour. *Population and Development Review* 27 (Supplement: Global Fertility Transition): 290-331.